

Энэ дугаарт Ардчилал, Сонгуулийн Тусалцааны Олон Улсын Хүрээлэнгээс 2015 оны 1 дүгээр сард гаргасан Бодлогын асуудлыг орчуулан хүргэж байна.

УЛС ТӨРД МӨНГӨНИЙ НӨЛӨӨ

Ардчилал бол шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн хяналт тавих тухай ойлголт бөгөөд наад зах нь онолын хувьд иргэд болон сонгуульд нэр дэвшигчид улс төрд шударга, тэгш эрхтэй оролцох тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай. Ардчилал тогтсон болон шинээр тогтож байгаа аль ч улс орны хувьд улс төрд мөнгөний нөлөө ихэсч улмаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явц болон сонгуулийн үр дүнд нөлөөлөхүйц хүчин зүйлүүдийн нэг болж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлигад өртсөн улс төрчид, төсвийн хөрөнгийг урвуулан ашигласан явдал, мансууруулах бодисын наймаанаас олсон бохир мөнгө улс төрд нөлөөлж буй байдал, хөрөнгөтэй хандивлагч ба улс төрчдийн сэжигтэй харилцаа холбооны талаар дуулиантай мэдээлэл цацдаг. Энэ бүх нөлөө нь улс төрд тэгш өрсөлдөх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс улс төрийн санхүүжилт нь олон оронд үндэсний хэмжээний асуудал болж байна.

Ялангуяа сонгуулийн зардлыг бууруулах нь чухал асуудал. Олон оронд сонгуулийн кампанит ажилд ашиглаж

байгаа их хэмжээний санхүүжилт нь (үүний дотор мөнгөн бус хэлбэрийн хандив, бараа үйлчилгээ багтана) түүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгө босгож чадахгүй байгаа хүмүүсийг сонгуульд ижил түвшинд өрсөлдөх боломжгүй болгодог. Ялангуяа эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн санхүүжилт олох боломжгүйгээс нэр дэвших, сонгогдох боломжоо алдсаар байна.

Мөнгөний эх үүсвэр ба зориулалтыг илүү тунгалаг, ил тод зохицуулах зайлшгүй шаардлагатай. Тухайн орны нөхцөлд тохирсон, хэрэгжихүйц, сайтар боловсруулсан улс төрийн санхүүжилтийн хууль тогтоомж нь улс төр дэх мөнгөний эерэг нөлөөг нэмэгдүүлэх аливаа хүчин чармайлтад амин чухал үүрэг гүйцэтгэдэг.

Улс төрийн намууд болон нэр дэвшигчдэд сонгуулийн ба сонгуулийн бус үед улс төрийн үйл ажиллагаа явуулахад нь мөнгө хэрэгтэй. Иймд төрөөс олгох санхүүжилт нь томоохон хандивлагчдын нөлөөг багасгаж тэнцвэржүүлэх, улс төрийн намуудын өдөр тутмын үйл ажиллагааг дэмжихэд голлох үүрэг гүйцэтгэдэг. Үүнээс гадна

улс төрийн намуудад төрийн санхүүжилтийн ил тод байдал ба хүйсийн тэгш эрхийг хангах дүрмийг сахиулах зэрэг тодорхой нөхцөлтэй олгох хөшүүрэг болгон ашиглаж болно.

Бодлогын зөвлөмж

Өнөөгийн ардчилсан улс орнуудын улс төрийн бодлогод мөнгөний сөрөг нөлөөг багасгахын тулд Ардчилал, Сонгуулийн Тусалцааны Олон Улсын Хүрээлэнгээс дараах зөвлөмжийг гаргаж байна:

- **Мөнгө цуглуулах болон зарцуулах “уралдаан”-ыг зогсоох.** Сонгуульд их хэмжээний мөнгө зарцуулдаг улс орнуудад улс төрийн тоглоомын дүрмийг бүх оролцогчдын хувьд адилхан болгохын тулд томоохон хандивлагчдын нөлөөллийг бууруулах; улс төрийн зорилго нь мөнгө биш гэдгийг сонгогчдод харуулах, ингэхийн тулд бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид мөнгө цуглуулах ба зарцуулах “уралдаан”-ыг зогсоох арга замыг эрэлхийлэх шаардлагатай юм. Үүнд, эрх зүйн зохицуулалтын хувьд сонгуулийн хандив ба зардалд



АРДЧИЛАЛ,
СОНГУУЛИЙН
ТУСЛАЛЦААНЫ
ОЛОН УЛСЫН
ХҮРЭЭЛЭН

www.idea.int

Ардчилал, Сонгуулийн Тусалцааны Олон Улсын Хүрээлэн (IDEA) нь дэлхий даяар тогтвортой ардчиллыг дэмжих зорилготой засгийн газар хоорондын байгууллага юм. Уг Хүрээлэн нь 15 гаруй жилийн туршид Засгийн газар болон улс төрчдөд тухайн орны улс төрийн санхүүжилтийн тогтолцооны загварын талаар зөвлөгөө өгч, нийтлэл гаргаж, мэдээллийн сан ажиллуулж ирсэн билээ.

Улс төрийн санхүүжилтийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.idea.int/political-finance веб сайтаас үзнэ үү.

хязгаар тогтоох, бага хэмжээний хандив өгөхийг дэмжих, улс төрийн намуудад төрөөс мөнгөн болон мөнгөн бус санхүүжилт олгох алхмууд багтана.

- **Хувийн ба төсвийн санхүүжилтийг тэнцвэржүүлэх.** Зохистой байдлаар захиран зарцуулж, хуваарилсан тохиолдолд төрөөс улс төрийн намд олгох санхүүжилт нь хувийн хандивыг тэнцвэржүүлэх сайн хэрэгсэл болж, улс төрийн олон ургальч үзлийг мөн дэмжих ач холбогдолтой. Гэхдээ улс төрийн намууд сонгогчдоосоо хөндийрч эсхүл төсвийн санхүүжилтээс хэт хараат болж болохгүй. Тиймээс эрх зүйн зохицуулалт нь улс төрийн нам, нэр дэвшигчдийн төрийн болон хувийн санхүүжилтийн эх үүсвэрийг тэнцвэржүүлэх, иргэдтэй нягт харилцаатай байлгах санхүүгийн хөшүүрэг бий болгоход чиглэх ёстой.
- **Хүйсийн тэгш байдлыг дэмжих санхүүжилтийг шийдэх.** Улс төрд эхлэн хөл тавьж байгаа, эсвэл өрсөлдөж байгаа эмэгтэйчүүдэд тулгардаг хамгийн том саад бэрхшээлүүдийн нэг нь мөнгө цуглуулах, олох асуудал. Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтаар төрөөс санхүүжилт олгохдоо эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих замаар энэ асуудлыг шийдэж болно. Улс төрийн намууд санхүүжилтийн асуудалд хүйсийн тэгш байдлыг хангахад гол үүрэг гүйцэтгэх учиртай. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүжилт олгох дотоодын шинэтгэл хийх замаар шийдэж болно.
- **Намын болон нэр дэвшигчийн санхүүгийн мэдээллийг бүртгэж, нийтлэх.** Улс төрийн нам болон нэр дэвшигчдийн орлого, зарлагыг тогтмол бүртгэх

явдал ховор байдаг. Ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг бий болгохын тулд дүрэм журмыг сахиулах болон мэдээллийг тогтмол, цаг хугацаанд нь амархан олж үзэх боломжтойгоор ил болгох хүчин чармайлт гаргах шаардлагатай.

- **Хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг нь хангахад анхаарах.** Улс төрд мөнгөний зохицуулалтын хамгийн сул тал нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хэрэгжилтийг нь хангах асуудал юм. Хяналтын байгууллага нь мониторинг хийж байгаа улс төрийн тоглогчдоос хараат бус байх, чиг үүргээ биелүүлэхэд бие даасан байх асуудал нь хуулиар сайтар зохицуулагдах шаардлагатай. Хууль бус санхүүжилт болон төсвийн хөрөнгийг урвуулан ашиглах явдлыг таслан зогсоход нэн ялангуяа эрх зүйн хангалттай эрх мэдэлтэй байх нь чухал юм.
- **Бүс нутгийн сүлжээ байгуулж, дэмжих.** Одоогоор улс төрд мөнгийг хянах бүс нутгийн санаачилга бараг байхгүй байна. Бүс нутгийн сүлжээ нь нийтлэг стандарт, бодлого, дүрэм журам бий болгон хэвшүүлэх, нөлөөлөх бүс нутгийн орнуудын сул талуудыг илрүүлэх, мөн харилцан дэмжлэг үзүүлэх, мэдлэг, туршлага солилцох зорилготой хэлэлцүүлгийн талбар байж болно. Авлигын Эсрэг Бүлэг Орнууд хэмээх Европын орнуудын бүсийн санаачилгын үлгэр жишээг бусад бүс нутагт хэрэгжүүлж болох юм.
- **Улс төрийн санхүүжилтийн хууль тогтоомж боловсруулахад олон талын оролцоог нэмэгдүүлэх.** Улс төрчид мөрдөх дүрмээ тодорхойлох нь сонирхлын зөрчил зайлшгүй дагуулдаг. Эрх баригч болон сөрөг хүчний улс төрийн нам,

иргэний нийгмийн ба хууль сахиулах байгууллага зэрэг олон талыг оролцуулсан, илүү өргөн хүрээнд боловсруулсан хууль тогтоомж нь улс төрчдийн явцуу ашиг сонирхлыг бус, гол асуудлыг тусган шийдвэрлэх илүү боломжийг олгодог байна. Ингэх нь мөн улс төрийн намуудыг сонгогчдын нүдэнд илүү хууль ёсны харагдуулна.

- **Намуудын нийгэмд гүйцэтгэх гэж хүсч буй үүрэгт нь тулгуурлан хууль тогтоомжоо боловсруулах.** Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт нь улс төрийн намыг олон нийтийн сайн дурын байгууллага байхаас эхлээд төрийн шийдвэр гаргах түвшний байгууллага болох бүхий л хугацаанд намын үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг. Иймд энэхүү санхүүжилтийн асуудал нь өргөн хүрээг хамарсан улс төрийн амьдралын зохион байгуулалтын салшгүй хэсэг гэж үзэж зохицуулалтыг хийх хэрэгтэй.
- **Албан ёсоор батлагдсан хууль тогтоомж сул байх тохиолдолд бусад орны сайн туршлагыг хэрэгжүүлэх.** Улс төрийн намд итгэх итгэл буурч байгаа өнөөгийн нөхцөлд намууд үнэнч шударга байдлаа харуулах нь сонгогчдын итгэлийг буцаан олоход нь нэмэртэй юм. Энэ хүрээнд улс төрийн намууд санхүүгийн менежментийн тогтолцоог бий болгон хэвшүүлэх, мөн нягтлан бодох бүртгэлдээ онцгойлон анхаарч дотоод санхүүгийн үйл ажиллагаандаа ил тод байдлыг нэвтрүүлэх нь чухал юм. Намууд санаачилгаараа сайн туршлагаа олон нийтэд мэдээлэх, ялангуяа хууль бус санхүүжилтийг таслан зогсоход ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэнээ харуулах нь тэдэнд тустай байх болно.